

2026 он 6 сар 26 өдөр

№ 26/12

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Гүйцэтгэх удирдлагын баг томилох тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8, 76.1.13 дахь хэсэг, 83-р зүйлийн 83.1, 83.4, 83.5, 83.6, 83.8, 83.9, болон 83.13 дахь хэсэг, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрэм болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнгийн дагуу:

ҮНДЭСЛЭХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4 сарын 30-ны өдрийн хурлын 26/03 дугаар тогтоолоор компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багийн хэлбэрээр хэрэгжүүлэхээр өөрчлөлт оруулсныг;
2. Компанийн урт хугацааны стратеги төлөвлөлт, гүйцэтгэл, тогтвортой өсөлтийг хамтын удирдлагын шийдвэрээр хангах үүднээс доорх өөрчлөлтийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэнийг тус тус **ТЭМДЭГЛЭЖ**,

ТОГТООХ НЬ:

1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх удирдлагын баг (цаашид “Захирлуудын зөвлөл” гэх)-аар **ХЭРЭГЖҮҮЛСҮГЭЙ**.
2. Захирлуудын зөвлөл нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, стратегийн хэрэгжилтийг хангах, охин болон хараат компаниудын үйл ажиллагааг уялдуулан нэгтгэх бүрэн эрхтэй байхаар **ТОГТООСУГАЙ**.
3. Захирлуудын зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах албан тушаалтнуудыг багтаан, тэдгээрийн оролцоотойгоор хамтын шийдвэр гаргах зарчмыг **МӨРДСҮГЭЙ**.
Үүнд:

1. Г.Уянга - Ерөнхий Захирал бөгөөд Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
2. Г. Билгүүн – Санхүү эрхэлсэн захирал

3. М. Мөнх-Эрдэнэ – Аудит эрхэлсэн захирал
 4. Ө.Ашхүү - Комплайнс эрхэлсэн захирал
 5. А.Азбаяр - Компанийн нарийн бичгийн дарга
 6. Г.Сүхбаатар - Банкны нэгтгэлийн ахлагч
 7. Х.Билгүүн - Хөрөнгө оруулалтын банкны нэгтгэлийн ахлагч
 8. Н.Эрдэнэтулга - Даатгалын нэгтгэлийн ахлагч
4. Захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар **БАТАЛСУГАЙ**.
 5. Захирлуудын зөвлөлийн багийн ахлагчаар Г.Уянгыг сонгосныг баталгаажуулж, Г.Уянгыг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр улсын бүртгэлийн ерөнхий газарт **БҮРТГҮҮЛСҮГЭЙ**.
 6. Захирлуудын зөвлөлийн гишүүдтэй байгуулах хөдөлмөрийн гэрээний үндсэн нөхцөлийг энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталж, уг нөхцөлийн хүрээнд хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Ганхуягт **ОЛГОСУГАЙ**.
 7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг холбогдох албан тушаалтнуудад хуваарилж, хэрэгжилтийн явц, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлд тогтмол тайлагнаж байхыг Захирлуудын зөвлөлд **ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ**.

ДАРГА



Ч. ГАНХУЯГ